

## ӨВӨГ ДЭЭДСИЙН ӨЛГИЙ НУТАГ- ГУРВАН ГОЛ

«Зуун удаа дуулснаас нэгэн удаа үзсэн нь дээр» гэсэн хууч үг байдаг. Монголын гучин гурван говийн нэг Мандалын говийн хүн надад сэтгэл булаам үзэсгэлэнт Хэнтий хан, Гурван голын сайхан нутгаар гурвантаа аялах ховорхон завшаан тохиосон юм. Урьд нь энэ нутгийн түмэн сайхны тухай номноос мэдэж, олны шагшин магтахиг түмэнтээ сонссон бол энэ удаа өөрийн нүдээр үзэн биширч, бахархаж явлаа. Чухам үзэсгэлэнт гэсэн сонсголт сайхан үг ч багадаа нутаг юмаа. Япон хэлийг ядмагхан сурсан хэлмэрч надад үг хүрэлцэхгүй байснаа нуух юун.

1989 оны наймдугаар сарын есөн. Энэ өдөр БНМАУ-ын ШУА, Япон улсын хэвлэлийн томоохон пүүс «Емиүри» сонины газартай хамтран өндөр дээд өвөг-богд эзэн Чингисийн онгоныг эрэх «Гурван гол» төслийн хэлэлцээрт хоёр тал гарын үсэг зурж гурван голыг зорих бидний анхны аян эхэлсэн юм. Анхны аялалын маань зорилго эрэл хайгуулын эрдэм шинжилгээний ажилд оролцох эрдэмтэн мэргэжилтэн нарт эзэн Чингисийн төрж өссөн нутаг ус, түүх шастирт тэмдэглэсэн домогт газар оронг танилцуулах явдал байлаа. Газрын зураг авах хэрэгслээр тоногдсон АН-26 онгоцонд сууж Чингис хааны үйл амьдралтай холбогдох нутаг усны зураг авсаар Дадал сумын баруунтайх өргөн хөндийд газардахад Хэнтий аймгийн гүйцэтгэх захиргааны дарга Насан-Очир гуай биднийг угтан авч, Гурван нуурын амралтын газар хүргэн цайлж, нутаг орноо танилцуулж билээ. Түр алжаал тайлсны дараа амралтын газрын ойрхи Дунд нуурын хойд дэвсгэгт Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойгоор босгосон гэрэлт хөшөөг сонирхов.

Хөшөөний өмнөх нуур нь гурван нуурын дунд нуур бөгөөд хоёр талд нь нэг нэг нуур бий. Дунд нуурын дунд саяхан болтол нэгэн жижиг арал байсныг Чингисийн төрсөн гэрийн буурь гэдэг байжээ. Бас Чингис хааныг төрөхөд Өэлүн эх адууны дэлүүгээр шөл ууж биеэ тэнхрүүлснээр энэ хавийн нутаг Дэлүүн болдог нэртэй болсон домогтой. Тэндээс бид амралтын газрын зүүн хойно байх Дэлүүн болдог толгой дээр гарав. Өмнөөс нь машинаар гарч болохуйц, араасаа нэлээд эгцхэн юм. Энэ толгой дээрээс холын бараа сайн харагдах өвөрмөц сонин ажээ. Толгойн оройд том чулуу босгож худам монгол бичгээр «Дэлүүн болдог. Чингис хаан усан морин жил (1162) -ийн зуны тэргүүн сарын арван зургааны өдөр энд мэндлэв» гэж сийлжээ.

Проф. Эгами гуай машинаас буунгуут л ийш тийшээ хэд алхсанаа их л баяртай «бидний доорхи газар хөндий байна. Энэ чулуун хөшөө ганхаж хөдөлдөг нь мэдэгдэж байна» гэхчилэн ярьж том, хаадын булшийг газрын дор ордон байгуулан бунхалдаг, жижиг толгойн хэлбэртэй бунхалсан ч жишээ байх бөгөөд заримд нь яг түүнтэй адилхан хуурамч толгой босгож, хүмүүсийг төөрөлдүүлдэг удаа байдаг хэмээн ярьж Дэлүүн болдог толгой, хажуугийн баруун урд талын толгой хоёрыг сонирхон нас ная гарсан буурал гэхэд хөнгөн шингэн хөдөлж ийш тийш хурдан хурдан алхах нь сэтгэл ихэд хөдөлснийх биз.

Дэлүүн болдогийн баруун биеэр урсах Балж голд цутгах жижигхэн голыг Тэнгэлэг горхи гэнэ. Энэ нь Нууц товчоонд гардаг Түнхлэг гор-

хин гэдэг нэрээ өнөө хүртэл хадгалжээ. Тэнгэлэг горхины баруун, Дадал сумын төвийн баруун хойно байх дээрээ овоотой тэр хавьдаа арай өндөрлөг уулыг Баян-Овоо гэнэ. Энэ уулан дээр Чингис хаан хар тугаа тахидаг байж. Хар туг нь Чингис хааны аян дайны сүлд, түүнийг дайн тулаанд мордох, дайн тулаанаас нутагтаа буцаж ирэхдээ ёслон тахидаг байсан тухай угсаатны зүйч Бадамхатан гуай ярьж билээ.

Бас Дэлүүн болдогийн орой дээрээс баруун, баруун хойшоо холын бараа харагдах тул уул усны нэрийг хэлж, ардын арвин баян яриа домог хуучилсны нь Монгол, Японгүй их л анхааран чагнаж, тэмдэглэж авч байлаа.

Маргааш нь бид Дэлүүн болдог дээр дахин гарч дурсгалын зураг авахуулаад тэндээс баруун тийш явж Тэнгэлэг горхио гатлан Баян Овооны ар шилээр давж, Балж голыг бирваазаар гарч, Чингисийн тамганы чулуу хэмээх домогтой хүрэн өнгөтэй хоёр том чулуун дээр очсон юм. Энэ чулуу Чингисийн хүүхэд ахуйд цул бүтэн байснаа Монголын нэгдсэн төрийн гал голомт бадарсан өдөр тэр чулуу дундуураа хагарч, дотроос нь Чингис хааны тамга гарсан гэж домог өгүүлнэ. Гурван гол Дундаршгүй баян домгийн өлгий:

Гурван нуур бас нэрлэж баршгүй цэцэгсийн орон ажээ. Өнгө алаглан хуарлах цэцэгсийн үнэр хамар цоргиж, бие, оюуны алжаал тайлна. Ийм тэнгэр, ийм байгальтай монгол орноос баатрууд төрдөг нь аргагүй юмаа гэж япончууд шагшсан. Тэнд манай аялалынхан их Чингис хааны төрж өссөн нутаг, үйл ажил, ахуй амьдралын холбоотой газруудаар явж мал сүрэг нь налайсан хөдөө нутаг, буриад зоны айл хотоор бууж, морь уургалах, эмнэг сургахыг сонирхон, морь унаж, ходоод хэмээх морин тэргэнд сууж, амтат идээ цагаагаар дайлуулан мэхээртэй цөцгий, жимс ногоо, гарын талх, жимсний ундааны амтыг биширч явлаа. Аймгийн дарга Насан-Очир зочдод зориулсан дайллага, амралтын газрын хоол ундааг «Улаанбаатар ресторанаас элбэг дэлбэг, амт чанартай» хэмээн гайхаж, хот руугаа буцах болоход их л сэтгэл хоргодсон янзтай байцгаасан юм.

Хан Хэнтийг зорьсон хоёр дахь аялалаа намрын дунд сард хийв, 1990 оны 4-р сард эхлэх хээрийн хайгуулын ажилд хэрэглэх ажлын зураг хийх, сансрын хиймэл дагуулаас авсан зургийг компьютер ашиглан боловсруулахад газар орныг нүдээр үзэх, газрын гадаргуу өвс ургамалжилтыг ажиглах, хээрийн хайгуулын үеийн холбооны хэрэгсэл турших ажлаар Токой их сургуулийн Мэдээллийн төвийн захирал профессор Саката тэргүүтэй төлөөлөгчид Улаанбаатарт хүрэлцэн ирсэн юм. 10-р сарын 12-ны өдөр Улаанбаатараас нисдэг тэргээр гарч Мөнгөнморьт сумын төвөөс зүүн урагш Цагаан нуурын ойролцоо бууж, холбооны хэрэгслээ туршин, тэндээс хойшоо нисч Хэнтий хан уулыг давж Ононгийн халуун рашаан, Илүүрийн гол, Богдын голын хөвөөнд буухад намрын анхны цас тарлантаад их л сайхан байлаа.

Өвөг дээдсийн өлгий нутгаар аялах гурав дахь аялалаа цагаан морин жилийн хаврын дунд сарын гучны өдөр эхэлсэн юм. Тэр өглөө Тэнгэр хүйтэн, шороо шуурч, шамарга хаялах янзтай. Сүхбаатарын талбайн зүүн хэсэгт Чингис хааны цагаан туг сүлдийг өргөн, том гэр барьж үүдэнд хивс дэвссэн байх агаад өглөөний 9 цаг хагас гэхэд хүмүүс цугларч 13 дугаар зууны үеийг санагдуулмаар хөө хуяг, нум саадаг агссан морьт монгол цэргүүд. Япон улсад үйлдвэрлэж хээрийн хайгуулын ажилд ашиглахаар авч ирсэн дэлхийд сүүлийн үед ихээхэн нэрд гарч буй Мицүбиши пүүсийн пажэро машинууд тойрон зогсч эзэн Чингисийн цогцсыг эрж хайх хээрийн хайгуулын ёслолын ажиллагаа

эхэлсэн билээ. ШУА-ийн ерөнхийлөгч Н. Содном, Ёмиүри сонины ерөнхий редактор М. Абэ нар үг хэлж, хааны алтан цогцсыг хайх эрхийг олгох Чингисийн гэрэгийг Гурван гол хээрийн ангийнханд гардууллаа.

Монгол японы хамтарсан «Гурван гол» шинжилгээний ангийнхан тэр өдрөө Улаанбаатараас гарч Мөнгөнморьт сумаар дамжин 4-р сарын 25, 26-нд Хэнтий ханы баруун урд хажуу Бага давааны ар, Илүүр голын Цагаан эрэг гэдэг газарт байрласан хээрийн бааздаа хүрсэн юм. Гурван гол ангийнхны 5 гэр, 10 гаруй майхан мөн манай ангитай хамтран ажиллаж байгаа хоёр талын кино зураг авах хэсгийнхний гэр майхныг зэхсэн, нийт 80 гаруй хүний амьдарч ажиллах суурин отог маань ой хөвчөөр бүрхэгдсэн эзгүй энэ нутагт их л нүсэр харагдаж байв. 26-нд машинаар ирсэн хүмүүсээ угтан авч Хээрийн ажлын нээлт хийн баазын голд барьсан албан ажил явуулах гэрийн үүдэнд цагаан эсгий дэвсэж, бүгдээр цуглан, ангийн дарга С. Бадамхатан, С. Като нар өлзий дэмбэрэлтэй үг хэлж цагаан туганд мөргөн идээ ундаа ёсолж, уул хангайдаа дээж өргөн хүндэтгэл үзүүлэхэд бүх хүн их л итгэл бишрэл өвөрлөсөн нь илт байлаа.

Хайгуулын эхний өдрүүдэд хоёр удаа нисдэг тэргээр Монгол, Япон эрдэмтэд Ононгийн эх, Халуун рашаан, Богдын гол, Дуут хаан уул, Их, Дунд, Бага ахын гурван дэвээр явж ажиглалт судалгаа хийлээ. 27-ны өдөр энэ жил хээрийн хайгуул явуулах хэдэн газрын дотроос түрүүлж судлахаар тогтсон Их даваа орохоор бүгд явцгаасан юм. Их даваа баазаас хойш 7, 8-хан км зайтай боловч зам муу, урьд машин яваагүй, цас ихтэй, зарим газартаа хунгарласан, дов сондуултай, намхан торлог бүрхсэн, ургаа мод, унанги дархи ихтэй тул замдаа машин сууж, бие биеэ татах зэргээр саатаж байлаа.

Их даваа гэдэг нь зүүн талаараа Хэнтий хан уул, баруунаараа Их уул гэсэн хоёр уулын уулзвар, Хэнтийн уулсыг хойш давах хоёрхон даваа байдгийн нэг нь гэнэ. Хойд талдаа өндөр уултай, баруун зүүн талаараа уулаар хашигдсан, нар удаан цагаар ээдэг, урагшаа Цэлгэр хөндийрхүү, өтгөсийг тавихад их л тохиромжтой, үнэрхээр иймэрхүү л газар баймаар гэж бодогдмоор байлаа. Бадамхатан гуай эртний монголчуудын хун тавих ёс заншил, газар орны байдлыг танилцуулж, энэхүү Их даваанд Чингис хааны өвөг дээдсийн шарил бий гэж таамаглаж байгаагаа ярихад бүгд л чих тавин чагнаж байв. Их давааны энгэрийн ойд хоёр залуу модонд аянга бууж зад цохилгүйгээр зөвхөн холтсыг нь сүхээр цавчсан юм шиг ховил гарган газарт орсныг бодоход дор нь ямар нэг төмөрлөг байх боломжтой хэмээн ярилцаж байлаа. Гэвч хөрсөн дээр археологийн шинж тэмдэг огт байгаагүй. Ямар ч гэсэн Их давааны энэ хэсэгт геофизикийн хайгуул хийх нь зөв гэж бүгдээр хэлэлцсэн юм.

Хээрийн хайгуулын ангийнхан Их давааны баазад 5-р сарын 10- дьг хүртэл байрлаж, Нанзангийн овон, Бага даваа, Их давааны арын холбоо нуурын энгэр, Зүрх уул зэрэг газруудаар явж хайгуул хийн Бага давааны орчимд хүннүгийн булш илрүүлсэн билээ.

5-р сар гаруут л их давааны хавь нэлэнхүйдээ гэсч эхлэн, уулын цас хайлж энд тэндгүй горхилоод Илүүрийн гол гэсч, намаг гарч, зам улам муудан машин явахад хэцүү болсон тул хайгуулынхан нүүхээс өөр аргагүй болсон юм.

Их даваанаас Мөнгөнморьтод нүүж отог тур байрлах үед археологийн хэсгийнхэнтэй сумын төвөөс зүүн хойших Дэнслэнгийн адгийн дөрвөлжин булш, Чимэгт овооны энгэрийн хэсэг булш, Бурх голын эрэг дэх Хүннүгийн дөрвөлжин зэрэг газруудаар явж үзсэн юм. Дэнслэнгийн адгийн дөрвөн дөрвөлжин булш түрэгийн үеийнх гэнэ.

Булшны дэргэдэх хүн чулуунаас эхлэн олноор нь цувуулан тавьсан зэл чулуу байх бөгөөд зарим газарт энэ чулууны тоо 100 гаруй, үргэлжлэх урт нь 4,5 км ч хүрдэг гэнэ. Түрэгийн үед нэг овгийнхон бусадтай байлдаад алсан дайсны баатрын тоогоор чулуу босгож хөшөөний эзэнд бэлэг өргөдөг байжээ. Чимэгт овооны энгэрт хүрлийн үеийн хэдэн дугариг булш байна. Түрэгийн үед хүнийг зүүн зүгт харуулан тавьдаг байсан бол хүрлийн үеийн булш хүнийхээ толгойг хойд зүгт харуулж хөлийг нь атираан оршуулсан байдаг гэнэ. Дөрвөлжин булш нь хүн оршуулаагүй, харин тахилга хийдэг байсан. Тэгээд ч малтлага хийхэд малын яснаас өөр юм гардаггүй гэнэ. Дэнслэнгийн адгийн дөрвөлжин булшнаас зүүн урагш хойд Бүрх голын баруун эрэгт Хүннүгийн дөрвөлжинд очиход сүмийн суурь бололтой овгор шороо, мөн гадуурхи хэрмийн үлдэгдэл дөрвөлжин шороон далан, сүмийн дээврийн хээтэй ваарын хагархай тааралдав.

5-р сарын 16-нд Хэнтий ханы зүг дахин нүүж Босготын даваагаар давж, Хэрлэн голын эрэг дээр отоглож, Богдын голын хайгуулын ажилд орсон юм. 17-ны өдөр бүгдээрээ Богдын голыг өгсөн Хэнтий хан уулын зүүн суга хүртэл явж, Хэнтий ханы бага овоон дээр очсон билээ. Хэнтий хан гурван овоотой, Их, дунд, бага гурван овооны бага овоог Шүхэрт засгийн хошууныхан, одоогийн Мөнгөнморьт, Батширээт сумынхан, дунд овоог Сэцэнханыхан, Их овоог Монгол улс даяараа тахидаг байжээ. Хайгуулын ангийнхан Хэнтий хан уулын зүүн урд энгэрт орших Бага овооны өмнө талын тэгшхэн дэвсэг талбай, ойр орчмын толгойд археологи, геофизикийн хайгуул хийсэн юм. Энгэр нөмөр сайтай, нар удаан тусдаг, археологийн үүднээс үзэхэд булш байх тохиромжтой ажээ. Бага овооны өвдгийн ойролцоо хоёр ч хуучин булш илрүүлсэн бөгөөд эрдэмтэд ч үнэхээр сэжигтэй газар гэдэгт санал нийлж байсан юм.

Хэнтий ханыг тахиад Их хүрээнээс тусгай лам очдог байжээ. 1919 онд болсон тахилгын ёслолд Довчин унзад тэргүүтэй 7 лам Их хүрээнээс ирээд тэргүүн лам Довчин унзад гэнэт нас баржээ. Түүнийг Бага овооны өвдөгт оршуулж, маанын үсэг сийлсэн чулуу тавьсан нь өнөө ч хэвээрээ байна. Үлдсэн 6 лам Их овооны тахилгат оролцох байгаад 2 залуу лам нь Хэнтий хан уулын хойд уруу доош нисч үхсэн гашуудалт явдал болжээ. Түүнээс хойш Их овооны ар соронзтой, өнгийсөн амьтныг татаж унагаадаг гээд хүн ойртохоо байжээ.

Хэнтий хан уулын зүүн урд хормойд, бидний хайгуулын талбайгаас хойш 100-аад метрт орших Бага овоог модоор босгож, өнгө өнгийн даавуу торго, морины хялгас зэргийг уяж, ойр орчмынх нь модонд хийморь олныг хийсгэсэн харагдана. Бага овооноос дээш гарсан нарийн жимээр өгсвөл уулын дунд хирд байх дунд овоонд хүрдэг ажээ. Дунд овоог мөн л модоор хийсэн байх бөгөөд урд талд нь гурван тогоог зэрэгцүүлэн тавьжээ. Томыг нь хүрлээр цутгасан, хажуугийн хоёр нь хоёул гурван хөлтэй, хоёр чихтэй бөгөөд том тогоонд шахмал цай, чихэр боов, ёотон зэргийг өргөжээ. Хоёр жижиг тогоо нь хагарсан байна. Дунд овооны хажууд дээр үед хөөрхөн сүмтэй байсныг гучин хэдэн онд эвдэлсэн гэнэ. Одоо сүмийн туурь овгор овгор шороо үлдэж, хана дээврийн ваарын үлдэгдэл газраас цухуйж харагдана. Уулаа тахидаа гурван тогоог сүү саалиар дүүргэж, том тогоонд шүүсээ болгон тэндээс идээ цагааны дээжийг Дээд овоонд хүргэх хамгийн хүндтэй хүмүүсээ тусгай элч болгон томилж явуулдаг байжээ. Овоо тахилгын үед Богдын голын урд эргийн Удган мод хэмээх ганц модны дэргэд наадам хийж, бөх барилдан (манай отог байрлаж байсан) Хэрлэнгийн хойд эргээс Удган модыг хүртэл морь уралдуулж

байжээ. Гол үерлэж, овоонд хүрэхэд бэрхтэй болсон үед Босготын даваан дээр Хэнтий хан уул харагдах газарт овоо тахилгыг ёсолж, наадмаа хийдэг байсан гэнэ.

Дунд овооноос уулыг хярлан тойруу замаар дээш өгссөөр Их овоонд хүрэх замтай ажээ. Тэр замаар хэсэг явахад Хэнтий хан уулын дунд хирд нэг их сайхан нуур дайралдана. Галт уулын тогоо шиг тал бүрээрээ уулаар хүрээлэгдсэн нэлээд гүн бололтой хонхорхойд тогтсон том нуур ажээ. 5-р сарын сүүлч болсон ч нуур хөлдүү, бид нуурын мөсөн дээр зогсч зураг татуулж билээ.

Богдын голын хайгуулын үед манай отог буусны урд талын өндөр давааг Босготын даваа, баруун урд өндрийг Босгот уул, давааны урд өндрийг Их сайхан гэнэ. Богдын голын хайгуулын явцад монгол, Японы эрдэмтэд Хэнтий ханы Бага овооны өвдөг, Богдын гол, Аргун байдангийн таван толгой, Их ахын дэв, Дунд ахын дэв зэрэг газарт хайгуул хийсэн билээ. Соронзон, цахилгаан хайгуулын багажаар хийсэн судалгаагаар Их давааны адил гажил сэжигтэй газрууд цөөн боловч илэрч байсан хэдий ч үр дүнг нь шууд булш мөн биш гээд хэлчихэж болдоггүй, нарийн ажиглалт судалгаа, хэмжилтийн тоо баримт боловсруулалт, өндөр мэдрэмтгий тооцоолон бодох машинаар судалсны үндсэн дээр нарийн тодорхойлох шаардлагатай учир эхний жилийн хайгуулын үр дүн судалгааны материал боловсруулалтын эцэст тодрох ажээ. Тэгээд ч хайгуул явуулж буй нутаг элдэв төрлийн эрдэс чулуулаг, төмрийн хүдрээр баялаг, хөрсөн доорхи ийм зүйлс нь хайгуулын багаж төхөөрөмжид нөлөөлөх нь ч байдаг ажээ.

Эрдэмтэд, судлаачдын үзэж байгаагаар эртний Бурхан халдун хэмээгдэх Хэнтий хан уул, Богдын гол, Их, Дунд, Бага ахын дэвүүд, Аргун байдангийн хавь газар нь их хааны шарил нойрсож байж болох ихээхэн найдлага төрүүлж буй нутаг ажээ.

Хэнтий ханы туж нуруу гурван голын Дэлгэр нутгаас хааны шарилыг олно гэдэг өвсөнд гээсэн зүү эрэхийн адил сэтгэлд нэг л багтахгүй санагдана. Нуухыг нууж чаджээ. Онгоныг олж гэмээнэ орчин цагийн нарийн техник, шинжлэх ухаанд бишрэхээс аргагүй.

**Б. СЭРЖАВ**